



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 06 сарын 28 өдөр

Дугаар 57

Эрдэнэт

Аймгийн авто замын тээвэрт баримтлах
бодлогын баримт бичиг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг, дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны Ээлжит III хуралдааны 01 дүгээр тогтоолоор баталсан “Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 6 дугаар зүйлийн 6.11 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Аймгийн авто замын тээвэрт баримтлах бодлогын баримт бичгийг хавсралтаар баталсугай.

2.Дээрх бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжилтийг зохион байгуулж, шаардагдах төсөв, хөрөнгийг тухайн жилийн аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт тусган батлуулж, биелэлтийн явцыг жил бүрийн IV улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулж байхыг аймгийн Засаг дарга /Д.Батлут/-д даалгасугай.

ДАРГА



П.ПҮРЭВЛХАГВА

0010100